



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 123

Номгон

**Г Орон нутгийн өмчид хөрөнгө бүртгэж, Г
эзэмшигч тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-386 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтын XV.3.1-д заасан “ Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн тоног төхөөрөмж /Баянхонгор, Баянхонгор сум/ арга хэмжээний хүрээнд худалдан авсан 17 нэр төрлийн нийт 924490090 /Есөн зуун хорин дөрвөн сая дөрвөн зуун ерэн мянга ерэн/ төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг орон нутгийн өмчид бүртгэсүгэй.

2. Орон нутгийн өмчид бүртгэсэн хөрөнгийн эзэмшигчийг хавсралтаар баталж холбогдох байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсүгэй.

3. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Хавсралтад заагдсан хөрөнгүүдийг комисс томилж хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;

3.2 Баянхонгор, Өлзийт, Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Шинэжинст сумдад хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийг ашиглалтын болон түрээсийн гэрээгээр ашиглах аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

3.3. Түрээслүүлсэн хөрөнгийн түрээсийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, тоног төхөөрөмжид тавих хяналтын зардлыг жил бүр “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний төсөвт суулгах.

1190811

4. Жижиг дунд үйлдвэрлэлийг орон нутагт хөгжүүлэх зорилгоор байгууллага, иргэдэд ашиглуулсан болон түрээслүүлсэн тоног төхөөрөмжид тавих хяналтыг жил бүр хийж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлд танилцуулахыг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний гүйцэтгэх захирал /С.Батцэрэн/-д үүрэг болгосугай.

5. Хүлээн авсан тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор шалгарсан албан байгууллага, иргэдтэй түрээсийн болон ашиглалтын гэрээг нэг жилээр байгуулж аймгийн Орон нутгийн өмчийн газраар баталгаажуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

6.1. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

6.2. Түрээсийн болон ашиглалтын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

6.3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг 2020 оны 01 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



The image shows a red square stamp of the Bayankhongor Province People's Representative Khural. The stamp contains the text 'Баянхонгор аймгийн Хурал' (Bayankhongor Province People's Representative Khural) and a central emblem. A black ink signature is written over the stamp.

Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны
өдрийн 123 дугаар тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БҮРТГЭЖ, ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

№	Нэр төрөл	Баянхонгор- Үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	Жинст	Борд	Баянлиг	Баянговь	Шинэжинст	Өлзийт	Шаргалжуут	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ				
1	Барабан		1	1	1	1	1	1		6	6466667	38800002				
2	Баркас		3	3	3	3	3	3		18	8994444	161899992				
3	Арьсны шар мах хуулагч, хутган махлагч		1	1	1	1	1	1		6	9383333	56299998				
4	Зулгуурийн машин		1	1	1	1	1	1		6	6333334	38000004				
5	Цахилгаан үүсгүүр / мотор/	2	20	20	20	20	20	20	10	132	1478940	195220080				
6	Вакум пресс	2	15	15	15	15	15	15	8	100	1544000	154400000				
7	Хонины ноос хяргагч	20	45	45	45	45	45	45	30	320	543437	173899840				
8	Цахилгаан саалтуур	25	5	5	5	5	5	5	5	60	1171668	70300080				
9	Оёдлын машин		1	1	1	1	1	1		6	1073334	6440004				
10	Цулууны жижиг хөрөө	1								1	1820000	1820000				
11	Багшийн ширээ	1								1	375000	375000				
12	Багшийн сандал	1								1	215090	215090				
13	Суралцагчдын ширээ	20								20	265000	5300000				
14	Суралцагчдын сандал	40								40	121500	4860000				
15	Зөөврийн компьютер	2								2	3105000	6210000				
16	Суурин компьютер	3								3	2880000	8640000				
17	3 үйлдэлтэй принтер	1								1	1810000	1810000				
										49302850	133291805	133291805	133291805	133291805	924490090	924490090

Нийт дүн

000